Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 20... оны .... дүгээр сарын ....-ны өдрийн ... дугаар албан бичгийн хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2024 оны 12 дугээр сарын 11-ны )

| № | ХБТББ*-т тусгагдсан зорилт/үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ** | Хэрэг-жих хугацаа | Үндсэн хэрэгжүү-лэх байгуул-лага | Эх үүсвэр | Нийт хөрөн-гийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэг-жил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (сая.төг) | Төсвийн гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| Бүлгийн нэр: **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**<br>Зорилго: 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | | | | | | | | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | **8** | **9** | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | | | | | | | |
| 43 | 6.1.11. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ | 2. "Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийг гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлийн түншлэл, төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, үйлдвэрүү-дийг үе шаттайгаар байгуулна. | 2021-2024 | НЗДТГ | Улсын төсөв, Нийслэлийн төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | | НБМҮТП-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулсан, 120 га талбайд үйлдвэрийн барилга байгууламжийг барих ажлыг эхлүүлсэн. | Дэд бүтцийн бүтээн байгуулалт, хувь - 20 | | | Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолд ЗГҮАХ-ийн 6.1.11.2 дахь арга хэмжээний 2023 оны хүрэх түвшинг “Дэд бүтцийн бүтээн байгуулалт, хувь–20” гэж төлөвлөсөн.<br>- Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дууссан, дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын БУА график, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгдэж байгаа бөгөөд одоогийн дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” бүрэн дуусаж техникийн комисс ажиллаж байна. Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын | 30 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | барилга угсралтын ажил бүрэн дуусаж агаарын шугамын хүчдэлээ өгч туршилт тохируулгын ажил хийгдэж байна.<br>- 2024 оны байдлаар нийт 31 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлээд байгаа бөгөөд хүсэлтүүдийг судлаж 27 аж ахуй нэгжтэй үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна.<br>- 2022 онд гэрээ байгуулсан 5-аас 1 үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээд байна. 4-н аж ахуйн нэгж үйлдвэрийн тоног төхөөрөмж угсралт суурилуулалтын ажил, гадна явган зам ногоон байгууламж тохижилтын ажил хийгдэж байна. .<br>- Цэвэрлэх байгууламж, Дулаан хангамж, Гадна цахилгаан хангамжийн зураг төсөв, бөөний болон жижиглэн худалдааны төвийн /ХЕТ/ боловсруулах ажлыг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 229-233 дахь заалтад тусгуулсан. Нийслэлийн 2025 оны төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлээд байна. | |